



## Есүс бол бидний Аврал Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

**Мөн чанар: Есүс бол бидний Аврал**

**Attribute: Jesus is our Salvation**

**Тодорхойлолт:** Аврал, Аврагч, Тэр бол бидний Хангагч, Хамгаалалт, Чөлөөлөгч, Эрүүл мэнд болон Эдгээгч.

**Эшлэл(үүд):**

- **Иохан 3:16** Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн тул Хүүд итгэдэг бүхэн мөхөхгүй харин мөнх амьтай байх болно.
- **Ром 10:9** Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно.
- **Иохан 6:40** Хүүг харж, Түүнд итгэгч бүр мөнх амьтай байх нь Эцэгийн минь хүсэл юм. Эцсийн өдөрт Би түүнийг амилуулна гэж айлдлаа.
- **1 Тимот 2:3-4** Энэ нь бидний Аврагч Бурханы мэлмийд сайн бөгөөд нийцтэй. 4Тэрээр бүх хүн аврагдаж, үнэний мэдлэгт ирээсэй гэж хүсдэг.
- **1 Иохан 5:20** Бурханы Хүү ирээд, бидэнд үнэн Нэгэнийг мэдүүлэхийн тулд ухааныг өгснийг бид мэднэ. Бид тэрхүү үнэн Нэгэн болох Түүний Хүү Есүс Христийн дотор байна. Тэр бол үнэн Бурхан бөгөөд мөнх амь билээ.
- **2 Коринт 6:2b** Авралын өдөр Би чамд тусалсан” гэж айлддаг. Харагтун, одоо тааламжтай цаг. Харагтун, одоо авралын өдөр.
- **Исаиа 45:8** Тэнгэр ээ, дээрээс цавд. Үүлс зөвт байдлыг цутгаг. Газар нээгдэж, авралыг ургуулан Түүний хамт зөвт байдал дэлгэрэг. ЭЗЭН Би үүнийг бүтээсэн билээ.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.* 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Иохан 3:16; Ром 10:9; Исаиа 45:8; 2 Тимот 2:10

**Библийн эшлэлээр залбирах:**

Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, би (Хүүхдийн нэр)-аа Таныг Хэн бэ гэдгийг гүнзгий мэдсэн мэдлэг дотор өсөж үнэнд итгээсэй гэж залбирч байна; Бурхан (Хүүхдийн нэр)-ийг маань ихэд хайрласан учраас цорын ганц Өөрийн Хүүгээ өгсөн, (Хүүхдийн нэр) маань Хүүд итгэснээрээ мөхөх биш харин мөнх амьтай болох болтугай. Эзэн, аврал (Хүүхдийн нэр) маань дотор урган бий болж хүүхэд маань Христ Есүс доторх мөнхийн алдарт авралыг хүртэх болтугай. (Хүүхдийн нэр) маань зөвт байдал дотор цэцэглэх болтугай.

**Залбирлын тодорхой хүсэлт:**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, би \_\_\_\_\_аа Таныг Хэн бэ гэдгийг гүнзгий мэдсэн мэдлэг дотор өсөж үнэнд итгээсэй гэж залбирч байна; Бурхан \_\_\_\_\_-ийг маань ихэд хайрласан учраас цорын ганц Өөрийн Хүүгээ өгсөн, \_\_\_\_\_ маань Хүүд итгэснээрээ мөхөх биш харин мөнх амьтай болох болтугай. Эзэн, аврал \_\_\_\_\_ маань дотор урган бий болж хүүхэд маань Христ Есүс доторх мөнхийн алдарт авралыг хүртэх болтугай. \_\_\_\_\_ маань зөвт байдал дотор цэцэглэх болтугай.  
*Иохан 3:16; Ром 10:9; Исаиа 45:8; 2 Тимот 2:10*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

***Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!***